



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/252

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 34 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвөөр хийгдэх ГААОНӨГ/202103037 дугаар бүхий “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ-т 18,9 литрийн цэвэр усны баллоны бэлдэц, бөглөө нийлүүлэх барааны нийлүүлэх ажлыг “Оюу энд эн интернешнл” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг “Гэгээн нуур цэвэр ус” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Ж.Бодьгэрэл)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг “Гэгээн нуур цэвэр ус” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Ж.Бодьгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР